

# ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД, САНГИЙН САЙД, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2020 оны ..... дүгээр  
сарын .....-ны өдөр

Дугаар ...../...../.....

Улаанбаатар  
хот

## Мэргэшлийн зэрэг олгох шалгуур үзүүлэлт батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн ... дүгээр зүйлийн ....Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 7-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Мал эмнэлгийн байгууллагад ажиллаж байгаа төрийн үйлчилгээний албан хаагчдад мэргэшлийн зэрэг олгох шалгуур үзүүлэлт”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2.Тушаалыг хэрэгжилтийг ханган ажиллахыг холбогдох төсвийн захирагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яам, Хөдөлмөр, нийгэм хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН  
САЙД

САНГИЙН САЙД

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД

.....

.....

.....

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд,  
Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын  
сайдын 2020 оны ...../...../...../ дүгээр хамтарсан  
тушаалын хавсралт

## **МАЛ ЭМНЭЛГИЙН БАЙГУУЛЛАГАД АЖИЛЛАЖ БАЙГАА ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ХААГЧДАД МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

Нэг. Мал эмнэлгийн байгууллагад ажиллаж байгаа төрийн үйлчилгээний (гүйцэтгэх, туслах) албан хаагчид нь I, II, III гэсэн мэргэшлийн зэрэгтэй байна.

1.1.Мэргэшлийн III зэргийг дараах шалгуур үзүүлэлтийг хангасан албан хаагчид олгоно. Үүнд:

1.1.1.бакалаврын, эсхүл мэргэжлийн чиглэлээр дипломын зэрэгтэй төгсөж, хариуцсан ажлын чиглэлээр нарийн мэргэжлийн арга зүйн сургалтад хамрагдсан нотолгоотой;

1.1.2.мэргэжлийн ур чадвараа ахиулж, мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр 2-оос доошгүй багц цагийн сургалтад хамрагдаж төгссөн;

1.1.3.мэргэжлээрээ тухайн байгууллагад үндсэн ажилтнаар 5 ба түүнээс дээш жил, тасралтгүй ажилласан;

1.1.4.хууль тогтоомж, стандарт, дүрэм журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, ажлын гүйцэтгэл нь сүүлийн 3 жил хангалттай үнэлэгдсэн;

1.1.5.Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх чадвартай, 1-ээс доошгүй судалгааны үр дүн хэвлүүлсэн;

1.1.6.мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ болон мэргэжлийн алдаа гаргаагүй;

1.2. Мэргэшлийн II зэргийг дараах шалгуур үзүүлэлтийг хангасан албан хаагчдад олгоно. Үүнд:

1.2.1.Мал эмнэлгийн боловсролын бакалавр болон мэргэшлийн III зэрэгтэй;

1.2.2.Мэргэжлийн ур чадвараа ахиулж, мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр 4-өөс доошгүй багц цагийн сургалтад хамрагдаж төгссөн;

1.2.3.Мал эмнэлгийн байгууллагад үндсэн ажилтнаар 10 ба түүнээс дээш жил тасралтгүй ажиллаж, шинэ санал санаачилга гарган, мэргэжлийн чиглэлээр 3 ба түүнээс дээш гарын авлага, 2-оос доошгүй дүрэм журам, стандарт, стандарт ажиллагааны заавар зэрэг эрх зүйн баримт бичгийг боловсруулж,

батлуулан байгууллагын үйл ажиллагаандаа нэвтрүүлж, хариуцсан ажлын чиглэлээр 2-оос доошгүй судалгаа хийж хэвлүүсэн;

1.2.4. Мэргэжлийн III дугаар зэрэг авснаас хойш 5 жил тухайн албан тушаалд үргэлжлүүлэн үр дүнтэй ажилласан

1.2.5. мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ болон мэргэжлийн алдаа гаргаагүй;

1.2.6. хууль тогтоомж, стандарт, дүрэм журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, ажлын гүйцэтгэл нь сүүлийн 3 жил хангалттай үнэлэгдсэн;

1.3. Мэргэшлийн I зэргийг дараах шалгуур үзүүлэлтийг хангасан албан хаагчдад олгоно. Үүнд:

1.3.1. мэргэжлээрээ тухайн байгууллагад үндсэн ажилтнаар тасралтгүй 15 ба түүнээс дээш жил ажилласан, мэргэшлийн II болон магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй;

1.3.2. мал эмнэлгийн чиглэлээр гадаад, дотоодын нарийн мэргэшүүлэх 4-өөс доошгүй багц цагийн сургалтад хамрагдаж төгссөн;

1.3.3. мал эмнэлгийн чиглэлээр 4-өөс доошгүй гарын авлага, мэргэжлийн чиглэлээр шинжлэх ухааны өгүүлэл хэвлүүлсэн;

1.3.4. Мэргэжлийн II дугаар зэрэг авснаас хойш 5 жил тухайн албан тушаалд үргэлжлүүлэн үр дүнтэй ажилласан

1.3.5. мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ болон мэргэжлийн алдаа гаргаагүй;

1.3.6. хууль тогтоомж, стандарт, дүрэм журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, ажлын гүйцэтгэл нь сүүлийн 3 жил хангалттай үнэлэгдсэн;

1.4. Төрийн албанаас халагдсан тохиолдолд мэргэшлийн зэрэг хүчингүй болно.

1.5. Шалгуур үзүүлэлтийн дагуу жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан төсвийн захирагч тушаал гарган зэрэг, зэргийн нэмэгдэл олгох асуудлыг шийдвэрлэнэ.

1.6. Төрийн албан хаагч нь Төрийн албаны тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.3 дахь заалтын дагуу саналаа удирдлагадаа гарган шийдвэрлүүлж болно.